

**Удирдах зөвлөлийн 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн
хурлаар нэмэлт өөрчлөлт оруулав.**

ХИС-ИЙН ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТЫН ЖУРАМ

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. ХИС-д төгсөлтийн шалгалтыг явуулахдаа Монгол улсын Гэгээрлийн Сайдын 1997 оны 9-р сарын 29-ний өдрийн 59 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын төгсөлтийн шалгалтын үлгэрчилсэн журам” болон энэхүү журмыг баримтална.
2. ХИС-ийн төгсөлтийн шалгалтын журам нь дээр дурьдсан үлгэрчилсэн журамд тус сургуулийн онцлогтой холбоотой нэмэлт тодотгол болох заалтыг агуулж байгаа ба бакалаврын сургалтын төгсөлтийн шалгалтыг зохион байгуулахад баримтална.

Хоёр. ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТ

- 2.1. Сургуулийн төгсөлтийн шалгалтын ерөнхий ба мэргэжлийн салбар комиссыг салбар сургууль, мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн ХИС-ийн захирлын тушаалаар томилно.
- 2.2. Төгсөлтийн шалгалтыг зайнаас өгөх оюутнуудыг ХИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 2.3. Төгсөлтийн шалгалтын комисс нь нарийн бичгийн даргаас гадна 2-3 гишүүнтэй байна. Гишүүдийн тоо, орлогч даргатай байх эсэхийг төгсөгчдийн тоо, шалгалт авах хичээл, мэргэжлийн төрөл, тоог харгалзан сургуулийн захиргаа тогтооно.
- 2.4. Сургалтын төлөвлөгөөнд өөр өөр хичээлээр төгсөлтийн шалгалт авахаар заасан бол тус бүрд нь, харин олон хичээлээр нэгтгэн шалгалт авч, төгсөлтийн ажил гүйцэтгэж хамгаалах бол нэгдсэн нэг салбар комисс байгуулна.
- 2.5. Комиссын гишүүдийн бүрэлдэхүүнд мэргэжлийн голлох эрдэмтэн багш нарыг оруулахаас гадна тухайн салбарын байгууллага, албанаас мэргэжилтэн урьж комиссын гишүүнээр ажиллуулж болно.
- 2.6. Бакалаврын төгсөлтийн шалгалт нь тухайн мэргэжлийн хувьд 4-аас хэтрэхгүй байх бөгөөд сургалтын төлөвлөгөөнд багц цагаар тусгагдана. Бакалаврын төгсөлтийн ажил нь сургалтын төлөвлөгөөнд 4 багц цаг тусгагдах бөгөөд голч оноо бодоход тооцогдоно. Бакалаврын төгсөлтийн ажил бичиж хамгаалсан оюутан төгсөлтийн нэг шалгалтаас чөлөөлөгдөнө.
- 2.7. Бакалаврын төгсөлтийн ажил бичих эрхийг нийт суралцсан хугацааны голч дүнгээр 3,0-оос доошгүй амжилт үзүүлсэн оюутан эдэлнэ. Улсын болон ХИС-ийн эрдэм шинжилгээний хуралд 1-3-р байр эзэлсэн оюутанд тэнхимийн саналыг үндэслэн бакалаврын төгсөлтийн ажил бичихийг зөвшөөрч болно. Энэ болзол, шаардлагыг хангаагүй оюутан зөвхөн төгсөлтийн шалгалт өгнө. Улсын хэмжээнд ажилладаг мэргэжлийн холбооны зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хурал, мэргэжлийн тэмцээнд 1-3-р байр эзэлсэн, рег review-тэй сэтгүүлд судалгааны үр

- дүнгээсээ хэвлүүлсэн оюутныг төгсөлтийн шалгалтаас чөлөөлж шалгалтын дээд оноог өгнө.
- 2.8. Салбар сургууль, тэнхимийн эрхлэгч тухайн жилд гүйцэтгэж болох бакалаврын төгсөлтийн ажлын сэдвийн жагсаалтыг хичээлийн жилийн 10-11-р сард гарган төгсөх ангийн оюутанд хүргэн, ил тод хадсан байна. Бакалаврын төгсөлтийн ажил бичих эрх авсан оюутан уг сэдвүүдтэй танилцан багш нар болон мэргэжлийн бусад хүмүүстэй зөвлөсний үндсэн дээр өөрөө сэдвийн сонголт хийнэ. Мөн бакалаврын төгсөлтийн ажлынхаа сэдвийг оюутан өөрөө бие даан дэвшүүлж болно.
 - 2.9. Мэргэжлийн байгууллага, судалгааны институт, болон бусад хамтран ажилладаг байгууллагаас захиалгат судалгааны ажлын хүрээнд дипломын ажлыг оюутнуудаар бичүүлж болно.
 - 2.10. Оюутны сонгосон сэдвийг мэргэжлийн тэнхим 12-р сард санал оруулж, тэнхимийн хурлаараа хэлэлцэн уг сэдвээр ажиллах зөвшөөрөл олгож удирдах багшийг томилно.
 - 2.11. Бакалаврынтөгсөлтийн ажил бичих оюутны нэр, сэдвийн нэр, удирдагч багшийн нэр бүхий дипломын ажил бичих тушаалыг сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.
 - 2.12. Сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлийг судалж зохих тооны кредитийг биелүүлсэн, “ХИС-ийн оюутан төгсгөх журам”-ын төгсөгчдөд тавих шаардлагын 1-3-р зүйлд заасан шаардлагыг хангасан оюутан төгсөлтийн шалгалтанд орох эрхтэй бөгөөд шалгалтанд орох оюутны нэрсийг ХИС-ийн захирлын тушаалаар нэгдсэн журмаар батална. Нэр нь тушаалд ороогүй оюутнаас төгсөлтийн шалгалт авахыг хориглоно.
 - 2.13. Бакалаврын төгсөлтийн ажлын урьдчилсан хамгаалалтыг жинхэнэ хамгаалалтаас дөрвөн долоо хоногийн өмнө тухайн тэнхимээс томилсон мэргэжлийн баг хийж, шүүмжлэгч багшийг томилох бөгөөд үүнээс хойш 7 хоногийн дотор оюутны нэр, сэдэв, удирдагч, шүүмжлэгч эцсийн байдлаар шийдвэрлэж, тушаалын хувийг төгсөлтийн шалгалтын комисст хүргүүлнэ.
 - 2.14. Төгсөлтийн шалгалтын агуулгыг тусгасан чиглэл, хөтөлбөрийг мэргэжлийн тэнхим холбогдох багш нар боловсруулж, шалгалт авахаас гурван сарын өмнө оюутанд хүргэн танилцуулсан байна. Мөн жишээлсэн шалгалтын материалыг боловсруулж, холбогдох дүрэм, журмын хамт оюутанд танилцуулах, тойм лекц, зөвлөгөөг сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан цагийн хэмжээнд багтаан харьяалах тэнхимээс зохион байгуулна.

Гурав. ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТ АВАХ БА ТӨГСӨХ

- 3.1. Төгсөлтийн шалгалтын комиссын гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй үед шалгалт авч, бакалаврын төгсөлтийн ажил хамгаалуулна. Шалгалтанд оролцсон сургуулийн төв ба салбар комиссын гишүүдийн ирцийг салбар комиссын дарга ирсэн, явсан цагаар нь бүртгэнэ. Комиссын дарга, нарийн бичгийн даргад шалгалт үргэлжилсэн хугацаанаас 2 цагийг илүү тооцно.
- 3.2. Төгсөлтийн шалгалт болон хамгаалалтын хурлыг комиссын дарга удирдана.

- 3.3. Төгсөлтийн шалгалт, хамгаалалтыг комиссын нээлттэй хуралдаанаар хэлэлцэж, дүн тавих үед хаалттай явуулна. Шалгалт, хамгаалалтын дүнг комиссын хурлын протокол гарсны дараа тэр өдөрт нь багтааж оюутнуудад албан ёсоор мэдэгдэнэ.
- 3.4. Төгсөлтийн шалгалтанд оюутны мэдлэг чадварыг 100 оноогоор үнэлэх ба тогтсон харьцаагаар А, В, С, D, F гэсэн үсгэн дүнд шилжүүлэн давхар гаргана. Шалгалтыг ам, бичиг, тест, дадлагын ажил гүйцэтгүүлэх зэрэг хосолсон хэлбэрээр авч болох бөгөөд онооны харьцааг мэргэжлийн онцлогийг харгалзан тогтооно.
- 3.5. Төгсөлтийн шалгалтыг зайнаас өгөх оюутнуудын шалгалтын материалыг тусгайлан боловсруулах ба оюутны амьдарч байгаа тухайн орон нутгийн цагаар эсвэл ХИС-н төгсөлтийн шалгалт авах хугацаанд авахыг салбар комиссын шийдвэрээр баталгаажуулж тогтооно.
- 3.6. Төгсөлтийн шалгалт, хамгаалалтанд комиссын гишүүд оюутны үнэлгээг тус бүрдээ тавьж, ерөнхий үнэлгээг тэдгээрийн дунджаар гаргаж шийдвэрлэнэ. Дүнгийн хуудас нь сургуулийн лого бүхий нэгдсэн загвартай байна.
- 3.7. Төгсөлтийн шалгалтын үргэлжлэх хугацаа өдөрт 10 хүртэл цаг байна. (Оюутны тоо, шалгалтын онцлогоос хамааран илүү гарахыг үгүйсгэхгүй)
- 3.8. Төгсөлтийн шалгалтаас хүндэтгэн үзэх шалтгаанаар хоцорсон оюутан салбар комиссын даргын зөвшөөрлөөр дараагийн хэсэг бүлэгтэй хамт нөхөн өгч болно.
- 3.9. Төгсөлтийн шалгалтанд хангалтгүй дүгнэгдсэн оюутан дараагийн бусад шалгалтуудад орох эрхтэй ба хангалтгүй дүн авсан шалгалтыг дараагийн 5 хичээлийн жилийн дотор төгсөлтийн шалгалтын хуваарьт өдөр өгнө.
- 3.10. Дахин шалгалт өгөх төгсөгч төгсөлтийн шалгалт өгөхөөс 3-6 сарын өмнө өргөдлөө сургуулийн захиргаанд гаргана. Төгсөгч нь голч дүнд нөлөөлөх 15-18 кр мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлээр дахин судалж дүгнүүлсэн байж болно.
- 3.11. Төгсөлтийн шалгалтанд хангалтгүй үнэлэгдсэн болон ороогүй оюутны төгсөлт хойшилсон тухай тэмдэглэгээг комиссын протоколд (хавсралт 1) заавал тусгана.
- 3.12. Салбар комиссын нарийн бичгийн дарга шалгалтын байр бэлтгэх, шалгалт авах өдөр, цагийг комиссын гишүүдэд тухай бүр мэдээлж байх, төгсөлттэй холбоотой бүх баримт бичгийг зохих журам, стандартын дагуу нямбай хөтлөн цэгцлэх, шалгалтын нууцлалыг хадгалах үүрэгтэй.
- 3.13. Төгсөлтийн шалгалтаа амжилттай өгсөн оюутанд ХИС-ийн төгсөлтийн шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн захирлын тушаалаар мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх диплом, энгэрийн тэмдэг олгоно.
- 3.14. Төгсөгчид диплом, энгэрийн тэмдэгний үнийг тогтоосон журмын дагуу төлнө.
- 3.15. Төгсөлтийн шалгалтаа 90-ээс дээш үнэлгээтэй өгсөн, сургалтын төлөвлөгөөний дагуу 120-оос доошгүй кредит судалсан, суралцах хугацаандаа нийт кредитийн чанарын үнэлгээ нь 3,7 онооноос дээш голч дүнтэй төгсөгчдөд онцгойлох диплом олгоно.
- 3.16. Төгсөлтийн шалгалтын төв ба салбар комисс нь шалгалт дууссаны дараа тайлан бичиж сургуулийн захиргаанд өгөх ба түүндээ бэлтгэж байгаа мэргэжилтний чанарын түвшин, сургалтын агуулга технологийн талаар дүгнэлт өгч, ажлыг цаашид сайжруулах арга хэмжээний талаар тодорхой санал, зөвлөмж оруулсан байвал зохино.
- 3.17. Төгсөлтийн шалгалтын салбар комисс нь дараах бичиг баримтыг бүрдүүлж төв комисст хүлээлгэн өгнө. Үүнд:
 - Төгсөлтийн шалгалтын салбар комиссын хурлын протокол /хавсралт-1/

- Шалгалтын нэгдсэн дүнгийн хуудас /хавсралт-3/
 - Комиссын гишүүдийн тавьсан дүнгийн хуудас /хавсралт 2/
 - Комиссын гишүүдийн цалингийн тооцоо /хавсралт-5/
- 3.18. Төгсөлтийн салбар комисс сургуулийн архивт төгсөх оюутантай холбогдсон дараах материалыг бүрдүүлж өгнө. Үүнд:
1. Төгсөх оюутны нэрсийн жагсаалт /мэргэжлээр/
 2. Сурлагын дүнгийн хувь-1 ш /дипломын хавсралт/
 3. Сурлагын дэвтэр
 4. Оюутны үнэмлэх
 5. Улсын шалгалт авсан тухай протокол
 6. Улсын шалгалтын материал, ноорог
 7. Тойрох хуудас
 8. Анкет

Дөрөв. ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

- 4.1. Төгсөлтийн шалгалтанд ажилласан комисс нь төгсөлтийн шалгалтын үнэлгээний хуудас /хавсралт-5/ -д комиссын гишүүн тус бүрээр хөдөлмөрийн хөлсийг тооцно.
- 4.2. Төгсөлтийн шалгалтын комиссын гишүүний хөдөлмөрийн хөлсний үнэлгээг кредитэд шилжүүлэн тооцох ба 1 кредитын үнэлгээг тухайн хичээлийн жил мөрдөж байгаа үнэлгээгээр тооцно.
- 4.3. Бакалаврын төгсөлтийн ажилуудирдах, шүүмж бичихэд тооцох кредитийг “ХИС-ийн эрдэмтэн багш нарын сургалт, эрдэм шинжилгээ-арга зүйн болон бусад ажлын ачааллыг тооцоход баримтлах журам”-ын 23-р зүйлийн хүснэгтийн 1-д заасны дагуу хөдөлмөрийн хөлсийг тооцно.
- 4.4. Тойм лекцийн цагийг сургалтын төлөвлөгөөнд заасны дагуу тэнхимүүдийн бодсон цагаар тооцож тусгана.
- 4.5. Төгсөлтийн шалгалтын тестийн үнэлгээг 1 багц тестийг 0,3 хүртэл кредитээр тооцно.
- 4.6. Төгсөлтийн шалгалтын комиссын гишүүний шалгалт авсан цагийг комиссын дарга шалгалт эхэлсэн дууссан цагийг тооцож үнэлгээг хийнэ.